




29Page



30Page



31Page



32Page

Хуримын найр

—The Wedding Feast—

- Тайлбарлагч** Дээр үед Галилын Кана хэмээх тосгонд нэгэн сайхан хуримын ёслол болжээ. Тэр өдөр хуриманд Есүсийн ээж Мариа болон Есүс, дагалдагчид уригдсан байв. Бүгд баяртай зүрх сэтгэлээр хуримын ёслолд оролцов. Тэнд хүмүүс амттай хоол идэнгээ баярлан хөгжилдөж цагийг сайхан өнгөрөөж байлаа.
- Найрын ахлагч** За бүгдээр сайн идэж уугаарай. Хоол унд хангалттай сайн байгаа шүү. Манай гэрлэж байгаа хоёр үнэхээр сайхан харагдаж байгаа биз? Хахаха
- Тайлбарлагч** Гэтэл яг тэр үед галт тогоонд үйлчилж буй хүмүүсийн царай нь цайчихсан санаа зовсон байдлаар найрын ахлагч дээр ирэв.
- Зарц1** Ахлагчаа, асуудал гарлаа. Найранд бэлдсэн дарснаас дусал ч үлдэлгүй дуусчихлаа.
- Найрын ахлагч** Юу гэнээ? Дарс дуусчихсан? Яанаа одоо яадаг билээ?, найрын дарс дуусна гэдэг! Үнэхээр том асуудал байна шүү. Холоос ирсэн зочиддоо юу өгнөө...
- Тайлбарлагч** Найрын ахлагч яах учраа олохгүй байх үед Есүсийн ээж Мариа усан үзмийн дарс дууссан болохыг мэддэг. Мариад гэнэт Есүсээс тусламж гуйж үзье гэсэн бодол төрдөг.
- Мариа** Есүсээ, найрын дарс бүгд дуусчихсан гэнэ. Ихэд л сандарч байх шиг байна. Туслах хэрэгтэй юм шигээ
- Тайлбарлагч** Энэ үед Есүс ээж Мариадаа ингэж хэлдэг.
- Есүс** Ээжээ, одоо хараахан цаг нь биш байна.
- Тайлбарлагч** Гэсэн ч Мариа Есүс туслана гэдэгт бат итгэлтэй байв. Тэгээд зарц нарт “та нарт Есүс юу гэж хэлнэ яг түүнийх нь дагуу хийгээрэй” гэж хэлдэг.
- Тайлбарлагч** Есүс зарц нарын байгаа газарт очиход тэнд том хэмжээний зургаан ширхэг чулуун торх байлаа. Тэр торхонд гаднаас орж ирсэн хүмүүсийн гар угаах ус болон цэвэрлэгээнд хэрэглэх усыг нөөцөлдөг байв. Есүс зарц нарт хандан хэлэв.

Есүс

Торхнуудыг усаар дүүргэ

Тайлбарлагч

зарц нар Түүний үгэнд дуулгавартай хандан бүгдийг усаар дүүргэв.

Есүс

За одоо уснаас утгаад найрыг ахлагчид аваачиж өг



33Page

Тайлбарлагч

Найрын ахлагч санаа зовсон байдалтай байлаа.

Найрын ахлагч

За одоо яадаг билээ. Ийм их хүнийг дайлах дарсыг хаанаас авдаг билээ. Ёстой нэрээ ийм ч юм болох гэж!

Зарц

Найрын ахлагчаа, найрын ахлагчаа энэ усан үзмийн дарсыг амсаад үз дээ!



34Page

Тайлбарлагч

Найрын ахлагч зарц нарын авчирсан дарсыг амсаж үзээд нүүрэнд нь инээмсэглэл тодров. Тэгээд ихэд баярлан сүйт залуу дээр очив.

Найрын ахлагч

Хүн бүр эхлээд сайн дарсааа гаргаад, хүмүүсийг согтсоны дараа муухнаа гаргадаг. Гэтэл чи сайн дарсаа одоо хүртэл хадгалсан байжээ!” хахаха

Тайлбарлагч

Тэр өдөр хуримын найрын зочид усаар хийгдсэн маш амттай усан үзмийн дарсыг ууцгаав. Хурим дуусан дуустал бүгд баярлалдан цэнгэж баяр хөөрөөр дүүрэн байцгаалаа.